

**ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ НЭЭЖ  
САНГИЙН САЙД С.БАЯРЦОГТЫН ХЭЛЭХ ҮГ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ӨӨ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭРХЭМ ГИШҮҮДЭЭ,  
ОЛОН УЛСЫН ХҮНДЭТ ТӨЛӨӨЛӨГЧИД ӨӨ,  
НОЁД ХАТАГТАЙ НАР АА,  
ТА БҮХНИЙ ЭНЭ ӨГЛӨӨНИЙ АМАР АМГАЛАНГ АЙЛТГАЯ!

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, түүний үр ашгийг дээшлүүлэх, татварын хувь хэмжээг бууруулж бизнес эрхлэх орчинг таатай болгох, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах, цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн ахиц гарлаа. Эдийн засгийн өсөлт өнгөрсөн 4 жилд дунджаар 9 хувь, хөрөнгө оруулалтын хэмжээ ихээхэн нэмэгдсэний зэрэгцээ сүүлийн гурван жилд төсвийн нийт тэнцэл ашигтай гарч, манай улсын гадаад валютын цэвэр албан нөөц 1 тэрбум ам.долларын босгыг давах болсон зэрэг Макро эдийн засагт гарсан нааштай үр дүнгүүдийг дурьдахад таатай байна. Ийнхүү эдийн засаг эрчтэй хөгжихөд манай улсын экспортын гол бүтээгдэхүүний үнэ гадаад зах зээл дээр өндөр байж, уул уурхайн үйлдвэрлэлийн салбар бүхэлдээ идэвхижсэнтэй холбоотой билээ.

Эдийн засагт ахиц дэвшил гарахын зэрэгцээгээр саад тотгор, бэрхшээл ч нилээдгүй байна. Тухайлбал, манай импортын гол бүтээгдэхүүн болох газрын тосны болон хүнсний бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр нэмэгдсэн нь инфляцийн түвшинд нөлөөлж манай улсын дотоодын үйлдвэрлэлийн зардал өсч, улмаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд хүндээр тусч байна.

Түүнчлэн манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, алт, цайрын үнэ сүүлийн үед огцом буурч, нэг тонн зэсийн үнэ 4710 ам.доллар, нэг унци алтны үнэ 848 ам.доллар, цайрын үнэ 1220 ам.доллар боллоо. **/10 дугаар сарын 20-ны өдрөөр тоог аваг/** Дэлхийн эдийн засагт нүүрлээд байгаа санхүүгийн тогтворгүй байдал нь олон улсын хөрөнгийн биржүүд дээрх хувьцааны үнэ, түүхий эд, бүтээгдэхүүний үнийг өндөр хурдацтайгаар буурахад нөлөөлж байна.

Цаашид Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын тулд дотоод, гадаад хүчин зүйлсийг оновчтой ашиглах, импортын хараат байдлыг багасгах нь нэн тулгамдсан асуудал болж байна. Үүнтэй уялдаад уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй оруулж улс орныг үйлдвэржүүлж, хүн ардынхаа аж амьдралыг богино хугацаанд дээшлүүлэх зорилт тавигдаж байна.

Ийм цаг үед Эдийн засгийн бодлогын энэхүү чуулга уулзалт болж байгаа нь асуудлыг оновчтой шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой зүйл болж байгааг энд онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Манай энэ чуулга уулзалтад ОХУ-ын Ерөнхий сайд асан Егор Гайдар, Дэлхийн Банкны дэд ерөнхийлөгч Жим Адамс, Дэлхийн банкны ерөнхий эдийн засагч Жастин Лин, Аделаидын Их Сургуулийн профессор Ричард Помфрет болон УИХ-ын гишүүд, олон улсын байгууллагын төлөөлөгчид зэрэг нэртэй судлаачид, эдийн засагчид оролцож байгаад баяртай байна.

Энэхүү Эдийн засгийн чуулга уулзалтын ажилд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ”-ЫН  
ТАЛААР ДЭЛХИЙН БАНКНЫ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТ 2008  
ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДРИЙН 11.00 ЦАГТ БОЛОХ ХЭВЛЭЛИЙН  
БАГА ХУРАЛД ДЭЭР САНГИЙН САЙД С.БАЯРЦОГТЫН ХЭЛЭХ ҮГ**

ТА БҮХНИЙ ЭНЭ ӨДРИЙН АМАР АМГАЛАНГ АЙЛТГАЯ!

Монгол Улсын Эдийн засгийн бодлогын чуулга уулзалтыг 2008 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулах гэж буйтай холбогдуулан өнөөдрийн хэвлэлийн бага хурлыг хийж байна. 10 сарын 28-нд буюу эхний өдөр ОХУ-ын Ерөнхий сайд асан Егор Гайдар, Дэлхийн банкны ахлах эдийн засагч Жастин Лин, Аделаидын Их Сургуулийн профессор Ричард Помфрет болон УИХ-ын зарим гишүүн, олон улсын байгууллагын төлөөлөгчид зэрэг нэртэй судлаачид, эдийн засагчид илтгэл тавьж хэлэлцүүлэхийн зэрэгцээ харилцан мэдээлэл солилцох, туршлагаасаа хуваалцах юм. Чуулга уулзалтын дараагийн өдөр буюу 10 дугаар сарын 29-нд Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаар дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү дугуй ширээний ярилцлага дээр шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдээс илтгэл тавьж хэлэлцүүлэх юм. Энд гол нь ойрын 4 жилд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогын чанартай томоохон асуудлуудыг хөндөж ярина.

Чуулга уулзалтын эхний өдөр 10 дугаар сарын 28-нд Манай улсын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн тулгамдсан асуудлуудтай холбоотой сэдвээр судлаачид илтгэл тавьж, хэлэлцүүлэх бөгөөд тухайлбал, уул уурхайн салбарын хөгжлийн асуудал, түүнээс орох орлого, нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалаар баялаг орнуудын эдийн засгийн хөгжил зэрэг бидэнд санаа авах, бусдын сургамжийг сонсох өргөн боломж олгосон хэлэлцүүлэг болно.

Ялангуяа дэлхийн эдийн засгийн гэнэтийн өөрчлөлт хувьсамтгай байдал нь уул уурхайн салбар зонхилсон бүтэц бүхий улс орнуудын эдийн засагт хэрхэн эерэг, сөрөг үр дагавар авчирдаг талаар ярилцана гэж үзэж байна.

Энэхүү эдийн засгийн чуулга уулзалт нь манай улсын хувьд анх удаагаа болж байгаа бөгөөд Монгол Улсын эрчимтэй хөгжлийн гарааны цаг үед болж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм. Эдийн засгийн чуулга уулзалтад дээр дурьдсан нэртэй улстөрч, судлаачдаас гадна энэхүү чуулга уулзалтыг хамтран зохион байгуулж байгаа Дэлхийн банкны бүс нутгийн манай улсыг хариуцсан захирал Дэвид Доллар болон Олон улсын банк санхүүгийн байгууллага, хандивлагч түнш орнуудын төлөөлөгчид оролцоно.

Та бүхнийг уг чуулга уулзалтын ажлыг сурвалжилж олон түмэнд хүргэнэ гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГЫН ХҮРЭЭНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААР  
БОЛОХ ДУГУЙ ШИРЭЭНИЙ ЯРИЛЦЛАГА ДЭЭР САНГИЙН САЙД  
С.БАЯРЦОГТЫН ХЭЛЭХ ҮГ**

Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье.

Өчигдөр бид уул уурхайн салбар голлосон бүтэц бүхий улс орнуудын эдийн засагт гадаад дотоод хүчин зүйлийн үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад юу анхаарах, төсөв санхүү, уул уурхайн салбараас орох орлогын тухай зэрэг дэлхийн эдийн засгийн өнөөгийн бодит нөхцөл байдалтай уялдуулан өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явуулсан. Ялангуяа нэртэй улс төрч, судлаачдын тавьж хэлэлцүүлсэн илтгэлүүд нь ихээхэн сонирхолтой, ялангуяа манай улсын хөгжлийн өнөөгийн болон ойрын жилүүдэд хамаатай, сургамжтай байсан гэдгийг хэлэхэд таатай байна.

Өнөөдөр бид шинээр эмхлэн байгуулагдсан Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар ярилцана.

Монгол Улс ардчилалыг сонгож, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийг үндсэндээ туулж 18 жил болж байна. Өнгөрсөн хугацаанд бид зах зээлийн эдийн засгийн харилцааны үндсэн элементүүдийг бүрдүүлж, хувийн хэвшил манай эдийн засагт давамгайлж, ДНБ-ий 80 орчим хувийг бүтээж байна. Гэхдээ манай эдийн засгийн бүтэц өрөөсгөл, дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлээс шууд хамааралтай эмзэг хэвээрээ байна.

Нөгөө талаас Монгол Улс газрын доорхи нөөц баялгаа үр ашигтай оновчтой ашиглах замаар эрчимтэй хөгжих цаг үед тулж ирээд байна. Иймээс энэхүү хоёр хүчин зүйлийг зөв зохистой шийдвэрлэх явдал Монгол Улсын Засгийн газрын нэн тэргүүний тулгамдсан асуудал болж байна.

Манай Засгийн газар эдгээр асуудлыг оновчтой шийдвэрлэж иргэдийнхээ амьдралыг сайжруулах зорилтыг өөрийн үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгахыг эрмэлзсэн болно.

УИХ-ыг сонгох 2008 оны сонгуулийн үед МАХН, АН-аас сонгуульд оролцохдоо дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, МАХН, АН хамтран ажиллах талаар 2008 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан гэрээ, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэгт үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын танхимаараа хэд хэдэн удаа шүүн хэлэлцэж, саяхан УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны гол зорилго нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний үе шатны зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийнхээ аж амьдралыг сайжруулан, төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, өндөр хариуцлагатай ёс зүйт байдлыг хангаж, бүх шатны төр, засгийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах явдал юм. Энэхүү зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газар дараахь тэргүүлэх чиглэл, зорилтуудыг хэрэгжүүлнэ: Үүнд:

1. **Ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж** хууль эрх зүйн орчныг шуурхай шинэчлэн гаргах, ашигт малтмалын томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж орлогоос иргэдэд хуваарилах;
2. **Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр** төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхдээ уул уурхайн салбар, түүнийг дэмжсэн үйлдвэрлэл, хөдөөд жижиг дунд болон орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
3. Макро эдийн засгийн тогтворжилтийг улам бататган, экспортын баримжаатай хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, мал аж ахуй газар тариалангийн бүтээгдэхүүнээр **дотоодын хүн амын хүнсний хэрэгцээг хангах;**

4. **Бүх шатны боловсролыг** эрхэмлэн хөгжүүлэхийн хамт хөдөлмөрийн зах зээлийг бие даан ажиллах механизмтай болгон хөгжүүлэх, ажил олгогчид, үйлдвэрлэл эрхлэгчдийн захиалга, эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, инженер техникийн боловсролыг түлхүү эзэмшүүлэх замаар мэдлэгт тулгуурласан эдийн засгийн тогтолцооны суурийг бүрдүүлэх;
5. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, улсын үйлдвэрийн газар, өмчийн харъяалал харгалзахгүй иргэд, иргэний нийгмийн байгууллагад хэрэгжүүлэх, Монгол төрийн ой санамжийг эрс сайжруулах **улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог** бий болгож бэхжүүлэх;

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ улс орны эдийн засаг, нийгмийн үсрэнгүй хөгжлийн гарааны түүхэн хариуцлагатай үе болох 2009 онд хөгжлийн томоохон төслүүдийн бэлтгэлийг хангах, зарим төслийг эхлэхээр төлөвлөж байна. Уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх байр суурь нэмэгдэж, манай улсын эдийн засгийн бүтцэд томоохон өөрчлөлт гарч байгааг харгалзан, эдийн засгийн бодит салбар, ялангуяа боловсруулах салбарын хөгжлийг дэмжих, эдийн засгийн бүтцийг сайжруулах зорилтууд чухлаар тавигдаж байна.

Макро эдийн засаг, нийгмийн хөгжлийн хувьд дараахь үр дүнд хүрнэ гэж тооцож байна. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг жилд 12 хувиас доошгүй түвшинд хүргэн, эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн нөхцөлийг бүрдүүлнэ.
- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2012 онд 5000 ам долларт хүрнэ.
- Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж төлөвшүүлэх зэрэг болно.

“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, УИХ-ын дэгийн тухай хуульд заасны дагуу хэлэлцүүлэх бөгөөд уг хөтөлбөрийг батлагдан гармагц Засгийн газраас уг хөтөлбөрийг

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг “арга хэмжээ, хариуцах байгууллага, эзэн, хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн” гэсэн дэлгэрэнгүй үзүүлэлтээр батлан гаргаж, улмаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа нэн даруй зохион байгуулж, хэрэгжүүлж эхэлнэ.

Өнөөдрийн энэ дугуй ширээний ярилцлагад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад голлон оролцсон хүмүүс холбогдох танилцуулгыг дэлгэрэнгүй хийх бөгөөд дараа нь санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг Та бүхнээс хүсч байна. Дугуй ширээний ярилцлагад идэвхитэй оролцохыг Та бүхнээс хүч байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**САНГИЙН САЙД С.БАЯРЦОГТЫН  
“ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ”-ЫГ  
ХААЖ 10 ДУГААР САРЫН 29-НЫ ӨДӨР ХЭЛЭХ ҮГ**

Хүндэт зочид, төлөөлөгчид өө!  
Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа!

Юуны өмнө, “Эдийн засгийн бодлогын чуулга уулзалт”-д хоёр өдрийн турш идэвхтэй оролцон, эдийн засаг, нийгмийн хөгжлийн ололт, амжилт, сургамж, бэрхшээл болон цаашдын хөгжлийн хандлагын талаар санаа авууштай олон чухал санал, санаачилгыг дэвшүүлсэн Та бүгдэд гүн талархалаа илэрхийлье!

Өнөөдөр Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжих шилжилтийн үе үндсэндээ дуусч хөгжлийн шинэ гараан дээр тулж ирээд байгаа энэхүү түүхэн цаг үед “Эдийн засгийн бодлогын чуулга уулзалт” болж байгаагаараа чухал ач холбогдолтой болж байна.

Энэхүү чуулга уулзалтаар бид “Дэлхийн хөгжлийн хүрээн дэх Монгол орны хөгжил”, “Баялагийн нөөц ихтэй эдийн засгийг удирдах”, “Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр” гэсэн 3 салбар хуралдааныг зохион байгууллаа. Салбар хуралдаанаар Монгол Улсын эдийн засагт тулгамдсан асуудал болон цаашдын хандлагын талаар шүүн хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход үнэтэй хувь нэмэр орууллаа. Бид ойрын 4 жилд буюу манай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлогын нэг гол чиглэл нь уул уухайн салбарыг хөгжүүлэх асуудал байгаа. Эдийн засгийн бодлогын энэхүү чуулга уулзалтаараа уул уурхайн салбар голлосон бүтэц бүхий улс орнуудын эдийн засагт гадаад дотоод хүчин зүйлийн үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад юу анхаарах, уул уурхайн салбараас орох орлогоос төсөв санхүү ихээхэн хамааралтай улс орны хувьд төсвийн зарлагын бодлогоо хэрхэн тодорхойлж хэрэгжүүлдэг болох вэ зэрэг дэлхийн эдийн засгийн өнөөгийн бодит нөхцөл байдалтай уялдуулан өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явууллаа. Ялангуяа өмнөх өдөр нэртэй улс төрч, судлаачдын тавьж хэлэлцүүлсэн илтгэлүүд нь ихээхэн сонирхолтой, манай улсын хөгжлийн

өнөөгийн болон ойрын жилүүдэд хамаатай, сургамжтай байсан гэдгийг хэлэхэд таатай байна.

Энэ утгаараа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж буй энэ үед ихээхэн ач холбогдолтой боллоо.

Дэлхийн эдийн засагт нүүрлээд байгаа санхүүгийн тогтворгүй байдал, эрдэс түүхий эдийн үнийн огцом бууралтыг тооцон үзэж ойрын 4 жилд Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогоо оновчтой тодорхойлж хөтөлбөртөө тусгах шаардлагатай гэдэг нь өнөөдрийн хэлэлцүүлгээс харагдаж байна.

Өнгөрсөн хоёр өдөр гарсан санал, санаачилгыг бид амьдралд хэрэгжүүлэхийн төлөө ажиллах бөгөөд нийт оролцогч, төлөөлөгч, зочид Та бүхэн ч бидэнтэй хамтдаа Монгол Улсын ирээдүйн хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулж, шинэчлэлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллана гэдэгт Би итгэл дүүрэн байна.

Ийнхүү бид Монгол улсын эдийн засагт тулгамдсан асуудлуудыг тунгаан хэлэлцэж, тэдгээрээс гарах арга замаа тодорхойлсноор энэхүү чуулга уулзалтаа амжилттай өндөрлөж байна.

Тус чуулга уулзалтад өөр өөрийн салбар, хамт олноо төлөөлөн идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлэн, шинэлэг санал, санаачилгаа дэвшүүлсэн нийт төлөөлөгчид, зочид Та бүхэнд дахин талархал илэрхийлэхийн ялдамд, чуулга уулзалтаас гарсан санал, санаачлагыг хэрэгжүүлэхэд хүчин зүтгэл, идэвхи санаачилга гаргаж, эх орныхоо ирээдүйн хөгжил цэцэглэлт, ард түмнийхээ сайн сайхан амьдралын төлөө шинэ арга барил, шинэлэг сэтгэлгээгээр ажиллахыг уриалж байна.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа!